


БАГШЛАХУЙН МЕНЕЖМЕНТ

**Ph.D, профессор Ц.Нацагдорж
2015-2016 оны хичээлийн жил**



ТӨЛӨВЛӨГӨӨ

- Менежментийн тухай товчхон
- Багшлахуйн менежмент гэж юу вэ?
- Багш – менежер
- Багшийн имиж бүрдүүлэхүй
- Багшийн ёс суртахуун ба ёс зүй



Менежментийн тухай

ТОВЧХОН

- Менежментийн онолын хамгийн эхний хандлагыг *Шинжлэх ухааны менежмент* гэж үздэг. XIX зууны сэтгэгчид ажилчдын хөдөлмөрийн бүтээмж, үр ашгийг дээшлүүлэхийг сонирхож ажиглалт, туршилт явуулсны үр дүнд *ажлын ба байгууллагын менежмент* гэсэн менежментийн 2 чиглэл бий болжээ.
- Удирдлагын тухай системтэй үзэл бодол төлөвших эхлэл тавигдсан үеийг 1911 онд У.Тейлорын “Шинжлэх ухааны удирдлагын зарчим” гэсэн ном хэвлэгдэн гарснаас үүдэлтэй гэж үздэг байна.
- Байгууллагыг эмх цэгцтэй удирдахгүйгээр зорилгоо биелүүлж, үр ашигтай ажиллаж чадахгүй болох нь XIX зууны дунд үеэс аж үйлдвэрийн үсрэнгүй хөгжлийн урт удаан хугацааны түүхээр нотлогдсон байна.
- Англид анх удаа эхэлсэн аж үйлдвэрийн хувьсгал нь *удирдлагыг судлах* сонирхлыг хүчтэй төрүүлжээ. Энэ үзэл бодол нь цаашаа хөгжөөд байгууллагын хөгжилд удирдлага нь шийдвэрлэх хувь нэмэр оруулдгийг анх удаа Америкт нотлон харуулсан байна.



МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ТОВЧХОН

- Кибернетикийн шинжлэх ухаанд удирдлагын гурван үндсэн объект байдаг. Тэр нь:
- Амьд бие буюу амьтан
- Техник
- Хүн/хүмүүс/ юм. Эдгээрээс зөвхөн хүмүүсийг удирдах нэг хэсэг нь **шинжлэх ухааны менежмент** буюу ардчилал, зах зээлийн орчинд эрх чөлөөт хүмүүсийг удирддаг арга - хандлага юм. Үүнийг дараах зураглалаар томъёолж болно.



МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ



МОНГОЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

- Дэлхийн улс орнууд Чингис хааны менежментийг судалж монголчууд бол эрт дээр үеэс хүчирхэг төртэй “далай их Монгол улс”-ыг байгуулж байсан орны хувьд менежментийн асар их өвтэй орон гэж менежмент судлаачид үзээд Монголын менежментийн сэтгэлгээний хөгжлийг:
- Монголын эзэнт гүрнээс өмнөх үеийн төрийн удирдлагын өв уламжлал/МЭӨ 209-МЭ 1160/
- Их Монгол улсын үеийн менежментийн онцлог /1160-1260/
- Монголын Юань гүрний үеийн менежментийн онцлог/1260-1368/
- Монголын нэгдсэн улсын үеийн менежментийн онцлог/1368-1920/
- Төвлөрсөн тогтолцооны үеийн менежментийн онцлог/1921- 1990/
- Зах зээлийн тогтолцоонд шилжсэн үеийн менежментийн онцлог /1990-ээс өнөөг хүртэл/ гэж үечлэн авч үзэж байна.



МОНГОЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮҮСЭЛ

ХӨГЖИЛ

- Монголын менежментийн сэтгэлгээний түүхэнд Монголын эзэнт гүрэн болон дэлхийн 1000 жилийн гарамгай жанжнаар тодорсон Чингис хааны төр барьж байсан үе онцгой байр суурь эзэлдэг байна.
- Их Монголын засаг захиргаа нь цэргийн, аравтын зохион байгуулалттай, **хууль цаазат төрийн** үндэс суурийг тавьсан бөгөөд хэрэг бүрт **хууль дүрэм**, юм бүхэнд **журам тогтоож**, гэм бүрт **ял шийтгэл оноож**, улсын хэмжээгээр нэгдсэн хууль цааз, хатуу чанд сахилга бат тогтоож, **төрийн удирдлагын аппаратыг бүрдүүлсэн нь** дэлхийн менежментийн санд оруулсан том хувь нэмэр юм.
- Ийнхүү хүчирхэг төртэй байсны ачаар монгол үндэстэн баттай бүрэлдэн тогтож, үндэсний хэл соёл, зан заншлын нийтлэг бий болж, монгол төрхийн эдийн засгийн хэвшил, монгол аж төрөх хэв загвар буй болжээ.
- Чингис хааны онцгойлон авч үзсэн менежментийн нэг чухал чиглэл нь **хамтын удирдлагын зарчим** байв. Улсын дээд эрх барих “Их хуралдай”, хааны дэргэд сэцдийн зөвлөл байгуулж, “Улсын заргач шүүгч”-ийг бий болгосон нь захиргааны менежментийн эх суурь болсон байна.
- Монгол менежментийн уламжлал Манжид эзлэгдсэн үед ч, Богд хаант улсын үед ч, ардын хувьсгалын жилүүдэд ч баттай хадгалагдан монгол улсын тусгаар тогтнол, бие даасан байдлын төлөө үйлчилж ирсэн юм.



МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ

- Ардчилал, зах зээлийн нөхцөлд амьдарч, эрх чөлөөт хүмүүстэй хамтдаа аж төрж байгаа л бол хүссэн хүсээгүй шинжлэх ухааны менежментийг үйл ажиллагаандаа удирдлага болгохоос өөр аргагүй билээ. Манай монголчууд **“Усыг нь уувал ёсыг нь дагана”** хэмээдэг.
- Шинжлэх ухааны менежмент 100 гаруй жилийн түүхтэй бөгөөд байнга шинэчлэгдэн хөгжсөөр байгаа шинэхэн салбар юм.



МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ

- Аливаа хүч нөөцийг зохистой байршуулж, эрхэм зорилго/*mission*/, зорилтуудад/*objectives*/ хүрэхийн тулд:
 - ✓ Төлөвлөх
 - ✓ Зохион байгуулах
 - ✓ Хошуучлан манлайлах
 - ✓ Хянах зэрэг менежментийн функцийг хэрэгжүүлэх,
 - ✓ Асуудлыг бүтээлчээр шийдэх үйл явцыг *менежмент* гэнэ.

Менежментийн шинжлэх ухааны үндэстэй судалгаа
XX зууны эхэн үеэс эхэлжээ.



БАГШЛАХУЙН МЕНЕЖМЕНТ

- Манай улсын боловсролын салбарын практикт :
 - Багшлах
 - Сургах
 - Заах

гэсэн гурван үг идэвхтэй хэрэглэгддэг. Эдгээр үгс нь ганц хүний үйлдлийг тэмдэглэсэн биш, үүний цаад талд заавал суралцагч байж, түүний сурах үйлтэй холбогддог. Өөрөөр хэлбэл *Баги-суралцагч/шавь/-ийн*



хооронд нэгдмэл нэг зорилго байж, түүнийхээ төлөө хамтдаа хүчин чармайлт тавих шаардлагатай болно.




БАГШЛАХУЙН МЕНЕЖМЕНТ

- Монгол уламжлалд “Багш шавийн барилдлага”, “Багшийг шүтэх ёс” хэмээх нандин зүйл байсан. Энэ бол багш, шавь хоёр ураг төрөл мэт явах сайхан сэтгэлийг илэрхийлэхийн сацуу угаас багш, шавь хоёр сургах-сурах үйлээрээ холбогдож шүтэн барилдсан нэгдмэл чанартайг харуулсан хэрэг юм.
- Монгол гүн ухаанд багш, шавь, ном эрдэм хэмээх гурвал тэдгээрийн шүтэлцлийг “Гурван эрдэнэ” гэж нэрлэх нь бий. Багш суралцагч хоёр, аль нэггүйгээр нөгөө нь оршин байх бололцоогүйтэй адил ном эрдэм гэх дундын харьцаанд оршихгүйгээр мөн чанараа алдах болно.
- Энэхүү “ном” хэмээх нь хөдөлшгүй тогтсон хэв суртахуун, номлол тэргүүтэн, харин эрдэм гэдэг нь хүмүний амьдралд нийтлэгээр удирдамж чиглэл болж чадах мэдлэг, мэдээлэл юм. Тийм ч учраас монголчууд юухныг ч болов сур. Тэр бол эрдэм. Чамаас хэн ч авч чадахгүй өв хөрөнгө мөн” гэж сургадаг билээ. Үүнийг загварчлан үзүүлбэл:




БАГШЛАХУЙН МЕНЕЖМЕНТ

Багшлахуйн хялбар загвар



Багш, шавь хоёул нийлж эрдэм номоо үзэж багшлахуй нэг хэсэг хугацаанд хэрэгжжээ. Гэтэл шавь маань эрдэм номоо сурсангүй. Сурсан ч сэтгэл ханамжгүй үлджээ. Багш 16 цагийн лекц, 32 цагийн семинараа хийгээд дуусчихсан. Цалингаа бүрэн авсан. Харамсалтай нь шавь нар маань юу ч сураагүй байдаг. Багшлахуй нь хамтын хөдөлмөр учраас үр дүн нь олон хүчин зүйлээс шалтгаална. Ийм учраас өөрөөсөө гадна өрөөлийн хүчин чармайлтыг дайчлах менежментийн арга ухааныг ашиглах хэрэгцээ зайлшгүй шаардагдана.


БАГШЛАХУЙН МЕНЕЖМЕНТ



Энэ тохиолдолд багш, шавийн харилцаа орхигдож, харилцааны тэнцвэр судлагдахууны тал уруу хэлбийсэн. Үүнийг академик сургалт гэнэ




БАГШЛАХУЙН МЕНЕЖМЕНТ



Багш голлох үүрэгтэй болж харилцааны тэнцвэр багшийн тал уруу хэлбийсэн. Үүнийг “багш төв”-тэй сургалт гэнэ



БАГШЛАХУЙН МЕНЕЖМЕНТ



Шавь голлох үүрэгтэй болж харилцааны тэнцвэр шавийн тал уруу хэлбийсэн. Үүнийг “шавь төв”-тэй сургалт гэнэ



БАГШЛАХУЙН МЕНЕЖМЕНТ

- Багшлахуйн дээрх 3 загвар хэн бүхний мэдээжийн юм шиг хэрнээ онол баримтлал, арга зүй, практик үйл ажиллагааны хувьд зарчмын өөр өөр хандлагыг илэрхийлдэг ихээхэн ач холбогдолтой зүйл юм.




БАГШ-МЕНЕЖЕР

- Менежментийн онол, арга, хандлагаар удирдлагын үйл ажиллагаа явуулдаг хүнийг менежер гэдэг. Багш менежерийн хувьд мэргэжлийн үйл ажиллагааг тухайлбал, *суралцагчдын мэдлэг зохиомжлон бүтээх үйл ажиллагааг* менежментийн ухаанд тулгуурлан явуулна гэсэн үг юм.
- Зорилгодоо үр бүтээлтэй, үр ашигтай хүрэхийн тулд менежер менежментийн функцийг үр бүтээлтэй гүйцэтгэх учиртай.



БАГШ-МЕНЕЖЕР



Менежментийн функцийг загвар: 1-4 - төлөвлөх, зохион байгуулах, хошуучлах, хянах функцүүд, 5- асуудлыг бүтээлчээр шийдэх холбогч функц.

Асуудлыг бүтээлчээр шийдэх гол дээр эргэж буй төлөвлөлт, зохион байгуулалт, хошуучлал, хяналт гэсэн мөөр бүхий дугуйг зорилгод хүргэхээр менежер эргүүлнэ. Хэрэв менежментийн функцийг төлөөлсөн энэхүү дугуйн аль нэг мөөр дутуу хагас буюу эсвэл бүр байхгүй бол доголдоод ажиллахгүй болно.

БАГШ-МЕНЕЖЕР

- *Асуудлыг бүтээлчээр шийдэх нь* орчны байдалд тасралтгүй шинжилгээ хийх, асуудлын мөн чанарыг олох, магадлан тогтоох, шийдвэрийн талаар таамаглал дэвшүүлэх, асуудлыг шийдвэрлэх хувилбарууд гаргах, сонгосон хувилбараа хэрэгжүүлэх, үр дүнд нь хяналт үнэлгээ хийх цогцолбор ажиллагаа юм.
- *Асуудлыг бүтээлчээр шийдэх нь* менежментийн бүх шатанд гардаг учраас менежментийн функцийг үндсэн хэсэг бусад функцийг холбогч болдог.
- Зорилтуудыг олж илрүүлэн тэдгээрийг ирээдүй цагт хэрхэн хэрэгжихийг тодорхой болгох нь *төлөвлөлт* юм. Ерөнхийдөө *эрхэм зорилго/mission/, зорилго/Goal/, стратегийн зорилтуудыг/strategic objectives/* төлөвлөлтөөр илрүүлж, тэдгээрт хүрэх арга замыг төлөвлөлтөөр тодорхойлдог.



БАГШ-МЕНЕЖЕР

- *Зохион байгуулах нь* төлөвлөсөн зүйлийг ажил хэрэг болгохын тулд нөөцийг бэлэн байдалд оруулах үйл явц юм.
- *Хошуучлал нь* нэгэн төрлийн шийдвэр гаргах үйл ажиллагаа юм. Хүмүүст хэрхэн хандах талаар шийдвэр гаргаж, тэрхүү шийдвэр нь эргээд хүмүүсийн зан үйлд хэрхэн нөлөлөхийг хошуучлал гэнэ.
- Зорилгодоо хүрсэн эсэхийг мэдэх, хүрээгүй бол учир шалтгааныг илрүүлэн тогтоож, цаашид юу хийх хэрэгтэйг тодруулахад *хяналтын үүрэг* оршино. Стандарт тогтоох, гүйцэтгэлийн талаар мэдээлэл цуглуулах, харьцуулан үзэх, засал хийх, урьдчилсан арга хэмжээ авахад *хяналтыг чиглүүлнэ*.
- Менежерийн нэг шинж нь *түүний ур чадвар юм*. Ур чадвар бол ажил хэргийг үр дүн болгон хувиргах чанар юм. Ур чадвар төрөлхийн шинжтэй боловч менежерийн хувьд түүнийг амьдрал орчноос олж авах явдал элбэг тохиолдоно.



БАГШ-МЕНЕЖЕР

- Менежерийн үндсэн ур чадварыг:
 - техникийн/technical/
 - хүмүүнлэгийн /Human/
 - үзэл баримтлалын/Conceptual/ гэж гурав ангилсан байдаг.

Техникийн гэдэг нь: багаж төхөөрөмж, арга барил, тусгайлсан мэдлэг ашиглах чадвар, багшийн хувьд заах арга барил хамаарна

Хүмүүнлэгийн гэдэг нь: хүмүүсийн хоорондох харилцаанд үр дүн гаргах чадвар

Үзэл баримтлалын гэдэг нь: юмыг бүхэлд нь авч үзэх, алс хэтийг харж асуудлыг үр дүнтэй шийдэх чадвар гэж тус тус үзнэ.

Багш менежер хэмээх нь цол хэргэм мэт дуудах нэр биш, учир шалтгаан бүхий тогтолцоо, үүрэг хариуцлага, шинэ ухаарал, шинэ зам юм. Энэхүү шинэ замыг туулах онол, практик үйл ажиллагааны удирдамж бол менежментийн ухаан юм. Өөрөөр хэлбэл багшлах ажилдаа амжилт гаргая, өөрчлөлт хийе гэвэл хүссэн, хүсээгүй менежментийн ухаанд тулгуурлах хэрэгтэй. Тэгснээрээ менежментэд суурилсан багшлахуйг эзэмших болно.



БАГШИЙН ИМИЖ

- Багш бол сургуулийн нүүр царай, сүр сүлд юм. Тийм учраас багшийн төрх байдал, өнгө зүс, харилцаа, зан чанараас их зүйл шалтгаална. Чухам үүнд л имиж хэмээх ухагдахууны мөн чанар орших болно.
- “Image” хэмээх нь “дүр”, “дүрс” гэсэн утгатай англи үг юм. Энэ үгийг толь бичигт:
 - Ямар нэгэн юм, эсвэл хүний талаар оюун ухаанд байдаг төсөөлөл
 - Ямар нэгэн юм, эсвэл хүний бусад хүмүүст төрүүлж буй сэтгэгдэл
 - Аливаа дүр төрх, дүрс, ялангуяа толь, эсвэл линзээр үүсгэгдсэн дүрс гэх зэргээр тайлбарлажээ.

Имиж зөвхөн хүмүүсийн гадаад төрх, нүдэнд харагдах зүйл төдийгүй хүний мэдлэг, чадвар, сэтгэхүйн зэрэг зан үйлийн тогтсон хандлагыг бүхэлд нь илэрхийлдэг олон талтай, өргөн хүрээтэй ойлголт юм. Ийм учраас имижийг:

- Бие бялдрын имиж/эрүүл мэнд, хувцас хунар, үс зүс гэх мэт/
- Психологийн имиж/зан араншин, темперамент, дотоод ертөнц/
- Социал имиж/нийгэмд гүйцэтгэж буй үүрэг, зан үйл, харилцаа гэх мэт/ гэх зэргээр ангилсан байдаг.



ИМИЖ БҮРДҮҮЛЭХҮЙ

- Өөрийнхөө имижийг оновчтой бүрдүүлж чадвал багш хүн шавь нараа хошуучлан дагуулж аль болох зардал чирэгдэл багатайгаар амжилт олоход тус дэм болно. Тэр нь менежментийн арга ухаанд суралцаж түүгээр сэтгэж, ажил амьдралдаа хэрэглэж сурна гэсэн үг.
- Имиж бол чухамдаа хүний бусдад сэтгэгдэл төрүүлэх чадварыг илэрхийлнэ. Бусдад төрүүлсэн сэтгэгдлийн хэр хэмжээгээр хэв загварыг идэвхтэй идэвхгүй гэж 2 ангилна. Байгалиас заяасан дүр төрх, зан авир, ажил мэргэжлээс үүдэлтэй санамсаргүй бүрдсэн хэв загварыг идэвхгүй гэдэг. Мөн зүгээр л тиймэрхүү харагдах гэж зориуд бүрдүүлсэн хэв загвар бас идэвхгүйд тооцогдоно. Өөрөөр хэлбэл, аяндаа бий болсон эсвэл хувийн зан авиртаа хөтлөгдөж бий болгосон хэв загварууд идэвхгүй байдаг. Судалгаанаас үзэхэд: Харилцааны соёлгүй/65%/, заах арга барил муутай/49%/, амьдралын түвшин, царай зүс, гадаад үзэмжээр ялгаварладаг/38%/, ширүүн догшин, уурлаж загнадаг/33%/, хэл амаар доромжилж гутаадаг/33%/, шударга бусаар үнэлдэг/31%/ гэх мэтээр идэвхгүй хэв загвартай багшийг суралцагчид үнэлсэн байдаг.



ИМИЖ БҮРДҮҮЛЭХҮЙ

- Ажил амьдралын явцад өөртэйгээ харьцах тодорхой хүмүүс, олон нийтийн хүсэл таашаалыг судлан тооцож, чиглэл зорилготойгоор бүрдүүлсэн хэв загварыг идэвхтэй гэж үздэг. Дээрх судалгаанаас үзэхэд хүүхдэд таалагддаг сайн багшийн имиж бүрдүүлэхийн тулд юуны өмнө харилцааны соёлтой, заах арга барил сайтай, амьдралын түвшин, царай зүс, гадаад үзэмжээр яьгаварладаггүй, ширүүн догшин, зан авиргүй, уурлаж загнадаггүй, хэл амаар доромжилж гутаадаггүй, шударга үнэлдэг гэх мэт идэвхтэй хэв загвар бүрдүүлэх хэрэгтэй гэдэг нь тодорхой байна.
- Үүнээс үзвэл, идэвхтэй имиж бүрдүүлэхэд хэн боловч зохих ёсоор анхаарал тавих учиртай ажээ. Имиж бүрдүүлэх зарим хүчин зүйл гэвэл:
 - Мэргэжил, мэдлэг
 - Ёс зүй, чадвар
 - Хүнлэг чанар
 - Сэтгэл зүйн хүчин зүйлс багтана. Эдгээрээс гадна хүмүүст төрүүлэх сэтгэгдлийн 90 гаруй хувь нь тэр хүн яаж харагдаж, ярьж байгаагаас хамаардаг байна..




ИМИЖ БҮРДҮҮЛЭХҮЙ

- Багшийн имижийг хувцаслалт, дуу хоолой, гадаад төрх, багшийн үнэт зүйл зэргээр бүрдүүлж болно. Багшийн гадаад байдлаас бие бялдрыг илүү онцолдог ажээ.
- Харин гадаад төрх, яриа хоёроос гадаад төрхөд бус багшийн ярианд илүү анхаарал хандуулдаг гэж судалгаанд оролцогчдын 61% нь үзжээ. Багшийн хувцаслалтын ач холбогдлыг суралцагчид доогуур үнэлээгүй байна. Багшийн имижид багш ямар загвараар хувцаславал тохиромжтой вэ? гэсэн асуултын өгөгдөлд:
 - Сонгодог хэлбэрээр 25%
 - Энгийнээр 45,5%
 - Чөлөөт хэлбэрээр 45% гэсэн үзүүлэлт гарсан байна. Эндээс үзвэл, багш нарын хувцаслалтыг суралцагчид чухалчилдаг ч гэсэн тэднээс хээнцэр тансагийг хүсэн хүлээдэггүй юм байна.



ИМИЖ БҮРДҮҮЛЭХҮЙ

- Багшийн имижийн нэг чухал зүйл бол түүний яриа, дуу хоолойн өнгө, жүжиглэлийн хэмжээ бөгөөд эдгээр өгөгдлийн хувьд багшийн жүжиглэлийг 40%, харин багшийн яриа хөгжилтэй сэргэлэн байгаасай гэж 65,5% нь хүсдэг юм байна.
- Багшийн үнэт зүйл түүний имижийн нэг гол хэсэг юм байна.



Аль нь илүү чухал болохыг сонирхвол: Хүнлэг, хичээлээ сайн заадаг, харьцаа сайтайг онцолсон байна.

ИМИЖ БҮРДҮҮЛЭХҮЙ

- Багш дуу хоолойгоо эзэмдэх нь дуу авиагаа ямар зайнд хүргэхийг тооцож тохируулах тухай асуудал юм. Багшийн дуу хоолой үргэлжилсэн нэг хэвийн байхаас зайлсхийх хэрэгтэй.
- Тодорхой нөхцөл байдлаас шалтгаалж, багшийн дуу өндөр, нам болж, өнгө нь зөөлөн, итгэлтэй байгууштай. Түүнчлэн “тийм”, “зөв байна”, “баярлалаа”, “болж байна”, “сайн байна”, “чи юу гэж үзэж байна” гэх мэт урамшуулсан, дэмжсэн, халуун дулаан үгийг олон өнгө аясаар хэлдэг байгууштай
- Нүүр хувирлын арга техник нь багш баяр баясгалантай, тайван, өөртөө итгэлтэй, ялангуяа харцаар, төрх байдлаараа олон зүйлийг илэрхийлдэг, сэтгэл санааны таагүй байдлаа далдалж чаддаг байвал зохино.



ИМИЖ БҮРДҮҮЛЭХҮЙ

- Хэл ярианы техник нь багш үгийг цэвэрхэн тод хэлэх, хэт чанга бус, хэт намуун бус ярих, ярианы өндөр нам нь тухайн нөхцөлд тохирч өөрчлөгдөх нь чухал. Хэрэв багш нэг маягаар нуршин яривал суралцагчдад ядаргаатай болохын зэрэгцээ тэд сонсохгүй анхаарал нь сарниж, өөр зүйл хийж эхлэх жишээтэй.
- Хөдөлгөөний техник нь багш ангид хэрхэн алхаж гишгэх, хэрхэн суух, гараа ямар байрлалтай байлгах, толгойгоо яаж хөдөлгөх тэргүүтнийг эвсэлтэй, зөөлөн, урлагтай хийхийг хичээх нь чухал. Тухайлбал ангид хүндээр алхах, гараа их хөдөлгөх, толгойгоо янз бүрээр санжигнуулах нь суралцагчдын анхаарлыг сарниулдаг сөрөг талтай.
- Багшийн бусад хүмүүст нөлөөлөх техник гэж буй. Үүнд багшийн дууны өнгө, нүүрний хувирал, харц, инээмсэглэл, хэл яриа, үгийн аяс, хөдөлгөөн зэрэг олон тусгай техникийг эзэмших шаардлагатай. Гэхдээ багш хэт жүжиглэж “дүр” эсгэх нь гол бус өөрийнхөө үндсэн дүр төрхөөр байх нь чухал юм.



ИМИЖ БҮРДҮҮЛЭХҮЙ

- Хүний имижийг эвддэг зохисгүй зүйлийн нэг бол зан суртахууны доголдол юм. Жишээлбэл, хэдэр хэрцгий зан чанар нь уур уцаартай холбоотой гэж сэтгэл судлаачид үздэг. Уур бол сэтгэл зүрх хэт хөөрч, бие махбод балмагдаж, хэвийн байдлаа алдаж хямрахаас эхэлдэг байна. Судалгаанаас үзвэл, уурлах шалтгаан нь:

- Омог ихтэй бардам зангаас 94%
- Биеэ барих хянах ухамсар доройгоос 27%
- Юманд хүлээцтэй хандаж утга учрыг нь ойлгох соёл дутсанаас 32%

-Харилцагчийн буруу үйлдэлд бухимдсанаас 67% зэргээс болдог байна.

Мөн түүнчлэн муу зан гэж байна. Үзэл санаа, зан суртахуунд хэвшсэн гаж буруу дадал зуршил нь муу зан болж илэрнэ. Өөрөөр хэлбэл хүний сэтгэлд хорлонт муу зуршил тогтохыг муу зан гэдэг. Монголчууд аминчхан, овилгогүй, хуурамч, зусарч, сувдаг, атаач, хоёр нүүр гаргадаг гэх мэт халгаатай зуршлыг муу зан хэмээн жигшиж иржээ.



ИМИЖ БҮРДҮҮЛЭХҮЙ

- Багшийн имижд нөлөөлдөг нэн чухал зүйлийн нэг бол суралцагчидтай харилцах харилцааны хэм хэмжээ болохыг судалгаа харуулж байна. Тухайлбал:
- Багш суралцагчдадаа бүтээлчээр бие даан сурах чадвар эзэмшихэд нь анхаарч, тэдний эрэл хайгуул хийхэд дэмжлэг үзүүлэх
- Багш суралцагчдадаа хүндэтгэлтэй хандаж, сурах үйл ажиллагааг нь чиглүүлэн удирдах, зөвлөх
- Суралцагчийн мэдлэг чадвар, чармайлтыг шударга үнэлэх
- Багш, суралцагчдын харилцаанд хүндэтгэлтэй хандах
- Суралцагчдыг дарамтлах, ялгаварлан гадуурхахаас зайлсхийх



БАГШИЙН ЁС СУРТАХУУН, ЁС ЗҮЙ

- Өглөгийн эзэн, буяны садан байх хувь зохиол багш хүнд заяажээ. Гагцхүү энэ хувь зохиолыг хэрхэн эзэгнэх нь хүн бүрээс, өөрсдөөс нь шалтгаална.
- Хүн төрөлхтний нийтлэг хүчин зүйл нэмэгдэж глобалчлагдан тэр нь ерийн амьдралд өдөр бүр мэдрэгдсэн орчин цагт ёс зүйн асуудал оюун ухаанаа хөгжүүлэн боловсруулахаас дутахгүй чухлаар тавигдаж байна.
- Багшлахуйн менежментийг мэргэжлийн ёс зүйгээс ангид үзэх боломжгүй юм. Мэргэжлийн судлаач нарын бичсэнээр бол ёс суртахуун **morals** хэмээх Латин үгээс, ёс зүй **ethos** хэмээх Герег үгээс үүсчээ.
- Ёс зүй нь ёс суртахууныг судалдаг мэдлэгийн салбар буюу ёс суртахууны философи ажээ. Тэгэхээр ёс зүй нь шинжлэх ухааны салбар, харин ёс суртахуун түүний судлагдахуун болно.
- Монголчууд “Ёсгүй хүн сүүлгүй нохойтой адил” гэх буюу “Хүн ёстой нь дээр, нохой сүүлтэй нь дээр” хэмээн сургадаг.

БАГШИЙН ЁС СУРТАХУУН, ЁС ЗҮЙ

- Сайн муу, нүгэл буян, шударга, шударга бус, зөв бурууд хамаардаг хүмүүсийн зан үйл, ааш араншинг хориглож зөвшөөрөх замаар хүн, байгаль, нийгмийн өргөн харилцааг зохицуулах үүрэг гүйцэтгэнэ.
- Ёс суртахууны зохицуулалтын хэрэгслүүд нь ёс заншил, хэм хэмжээ, хууль дүрэм, дэг журам зэрэг юм. Нийтээр хүлээн зөвшөөрч, дагаж мөрддөг зан чанарын дүр төрх, хэвшиж тогтсон стандарт, хэрэгжүүлэх ёстой шаардлагын цогцыг ёс суртахууны хэм хэмжээ гэнэ. Энэхүү ёс суртахууны хэм хэмжээг албан ёсны болгож хуульчлан баталбал эрх зүйн зохицуулалт болдог байна.
- Үнэнч шударга, энэрэнгүй зөөлөн, эвсэг хамтач байх, эцэг эх, ахмад үеэ хүндэтгэх, хойч үеэ халамжлах гэхчилэн алхах гишгэх бүрт ямагт мөрдөгдөх учиртай бичигдээгүй хууль дүрэм олон бий.
- Хүний үйл ажиллагааг ёс суртахууны хэм хэмжээгээр чиглүүлэхэд түүний зарчим чухал үүрэгтэй. Ёс суртахууны зарчим нь төрт ёс, хуулиа дээдлэх, эх орон байгаль дэлхийгээ хайрлах, эв эеийг хичээх, өглөгч сэтгэлтэй байх, нэр төр алдар хүндийг хайрлан хамгаалах, хичээнгүй хөдөлмөрч, хүнлэг энэрэнгүй байх, шударга үнэнч ёсыг баримтлах зэрэг ажээ. Эдгээр зарчмууд нь ёс суртахуунгүй үйлээс сэргийлэх, буруудах, хэтийдэхээс урьдчилэн сэргийлдэг байна.

БАГШИЙН ЁС СУРТАХУУН, ЁС ЗҮЙ

- Нүгэл буян гэсэн ойлголт шашин, философи, шинжлэх ухаан гэхээсээ илүү манай ард түмний хувьд эгэл хүний амьдрал үйл ажиллагаанд угаас байдаг жам ёс, хүн бүхний мэдэх зүйл юм. Ёс суртахуунгүй муу үйлийг нүгэл гээд түүний эсрэг сайн үйлийг буян хэмээн ухаарч, нүгэлээс зугтаж, буяныг хураахын төлөө явцгаадаг билээ.
- Аливаа үйлийг хүн бие, хэл, сэтгэлээрээ үйлддэг. Тийм учраас **бие, хэл, сэтгэлийг үйлийн гурван үүд** гэнэ. Учир иймд бие, хэл, сэтгэл гурвыг үлэмж цэгцтэй, ариунаар авч явах нь ёс суртахуунтай амьдрахын эрхэм зорилго юм.
- Бие, хэл, сэтгэлээр үйлдэх арван хар нүгэл гэж буй. **Эс өгснийг авах, буруу хурьцах, амь таслах тэргүүтэй биеэр үйлдэх гурван гэм, хов жив хөөцөлдөх, худал хэлэх, дэмий чалчих, хараал хэлэх тэргүүтэй хэлээр үйлдэх дөрвөн гэм, хорлох сэтгэл, хомголзох сэтгэл, буруу үзэл хэмээх сэтгэлээр үйлдэх гурван гэмийг** тэвчихийг сурган номложээ.
- Эдгээр арван хар нүглийн дээр **ниваанис буюу гэмт сэтгэлийн таван хор нэмэгдэнэ**. Тэр нь **мунхаг, уур, омог, атаа, шунал** бөгөөд зовлонгийн үндэс болдог. Ууртай бол *асрахуй хийгээд нигүүлсэхүй сэтгэл үүсгэх*, шунал тачаалтай бол шунахайрдаг зүйлийнхээ *ой гутмаар бохир заваан зүйлийг бясалган бодох*, омог бардам бол аль болохоор өөрийн *дутагдалтай талаа олж харахыг хичээх* хэрэгтэй ажээ.



БАГШИЙН ЁС СУРТАХУУН, ЁС ЗҮЙ

- Нигүүлсэхүй-асрахуй сэтгэл хэмээх нь нэг зүйлийн хоёр тал юм. Хамаг амьтныг зовлонгоос гэтэлгэх гэсэн хүсэл тэмүүлэл, чин эрмэлзлийг **нигүүлсэхүй**, бусдад аз жаргал, хүссэн чин сэтгэлийг **асрахуй** гэдэг байна. Бусдыг зовлонгоос ангижрахад туслах нь өглөгч сэтгэл юм. Өглөгч хүнд буян үйлдсэний ач тус аандаа ирдэг. Өглөг бол зөвхөн эд зүйлээр хязгаарлагдах бус, сэтгэл оюуны хүрээг хамарна. Эрдэм номын буян хайрлаж, гэгээн замд хөтлөгчийн хувьд **багш өглөгийн эзэн** болно.
- Монголчууд хэзээнээс нааш багшийг шүтэх ёсыг эрхэмлэн дагаж, эрдэм номыг адислан дээдэлж ирсэн сайхан уламжлалтай ард түмэн билээ. “Оюун түлхүүр”, “Цаасан шувуу”, “Саналыг тодруулагч сарны гэрэл”, “Чингис хааны алтан сургаал”, Тоть шувууны сургаал”, “Асрамжлан сурах бичиг”, “Ардыг тэжээх рашааны дусал”, “Сав шимийн ном”, “Мандах нарны туяа”, “То вангийн гурван үсэгт ном”, “32 модон хүний үлгэр”, “Гэсэр баатрын тууж” зэрэг монгол мэргэдийн арвин их бүтээл, номын их чуулбар нь багшийн ёс зүйн баримтлалыг бүрэн цогцоор боловсруулжээ.



БАГШИЙН ЁС СУРТАХУУН, ЁС ЗҮЙ

- Ёс суртахууны өвөрмөц шалгуур болсон эр хүний арван эрдэмд “номд мэргэн, нойронд сэргэг, үйлэнд уран, үгэнд цэцэн, дайнд баатар, далайд усч, хуулинд шударга, хуриманд цовоо, дээдэд зусаргүй, доордод найртай” гэх буюу хатан хүний арван таван эрдэмд “номын ухаант шинж бүрдсэн, гоо сайхан зүстэй, санаа сэтгэл ариун, оёж эсгэхэд уран, ачлалт тахимдуу, энэрэлт эергүү, үйлд чадамгай, ааль араншин сайтай, зочломтгой, ухаалаг хэрсүү, үг сонсогч, ашдын хишиг дэлгэр, идээ арвин, өгөөмөр, хоёр үл аашлагч, ичгүүр сонжуургүй төгөлдөр” гэж сургажээ.
- Түүнчлэн эцэг хүний 5 эрдэм, эхнэр хүний 9 эрдэм, 3 хайран, 4 хичээх зүйл, 5 сайн, 5 чухаг, 6 гэмшил, 7 шившиг, 8 хөнгөн, 8 чухал, төрийн түшмэлд 15 эрдэм, хаан хүнд 35 эрдэм байхыг сургасан нь ажил мэргэжил, нийгэмд эзлэх байр суурь, нэр төр, үүрэг хариуцлага өндөрсөх тусам **эрдэм-билиг-чадварын тоо нэмэгдэж** байна. Жишээлбэл:

Эрдэмгүй болбоос нэг хайран

Энэ өдрийг зүгээр өнгөрүүлэх хоёр хайран

Энэ насанд өглөг буян эс үйлдвээс гурван хайран гэх ба “Авах гээхийн дөрвөн мөрт”-д

Хэнд эрдэм буй болвоос түүнд тус бий

Хэнд эе бий болвоос түүнд нөхөр бий

Хэнд эд буй болвоос түүнд харам бий

Хэнд эрх буй болвоос түүнд хилэнц бий хэмээн ёс зүйн талаас сургажээ.



**Анхаарал тавьсан Та
бүхэнд баярлалаа**

